



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 31

Мандалговь

Хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.6. дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Цагаан суварга, Дэл уул орчмын аялал жуулчлалын үзмэрийг тохижуулах, тэмдэг, тэмдэглэгээ байрлуулах ажлын дагуу хийгдсэн нийт 40,000,000 /дөчин сая/ төгрөгийн хавсралтад дурдсан хөрөнгийг Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгийн болон эргэлтийн хөрөнгийн дансанд бүртгэхийг үүрэг болгосугай.

2 Өлзийт сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Оюунханд)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгө бүртгэх ажлыг зохион байгуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2 Энэ тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
31 дүгээр тогтоолын хавсралт



Өлзийт сумын Засаг даргын Тамгын газарт
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

д/д	Хөрөнгийн нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн бүртгэл
1	Сүүдрэвч	1	3,488,450	3,488,450	Үндсэн хөрөнгө
2	Жорлон	1	3,518,800	3,518,800	Үндсэн хөрөнгө
3	Ландшафт	2	3,080,875	6,161,750	Үндсэн хөрөнгө
4	Мэдээллийн самбар	3	866,700	2,600,100	Эргэлтийн хөрөнгө
5	Хогийн сав	1	1,167,000	1,167,000	Эргэлтийн хөрөнгө
6	Гэрэлтүүлэг	4	300,000	1,200,000	Эргэлтийн хөрөнгө
7	Хамгаалалтын шон	800	22,980	18,384,000	Эргэлтийн хөрөнгө
8	Хамгаалалтын бариул	60	50,000	3,000,000	Эргэлтийн хөрөнгө
9	Тэмдэг тэмдэглэгээ	6	80,000	480,000	Эргэлтийн хөрөнгө
Нийт дүн				40,000,000 /дөчин сая/ төгрөг	